



МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖИЙН ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРЛЫН ТУШААЛ

2017 оны 02 сарын 03 өдөр

Дугаар A-19

Улаанбаатар хот

Гишүүнчлэлийн жилийн хөлс хөнгөлөх тухай

Монгол Улсын Компанийн тухай хуулийн 83 дугаар зүйлийн 83.1, "Монголын хөрөнгийн бирж" төрийн өмчит хувьцаат компанийн Дүрмийн 8 дугаар зүйлийн 8.1, 8.10.11 дэхь заалт, Гишүүнчлэлийн журмын 3.3.2 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ НЬ:


1. 2016 онд хийгдсэн нийт арилжааны үнийн дүнгийн 5-аас дээш хувьтай тэнцэх хэмжээний гүйлгээг дангаар хийсэн хавсралтад дурдсан нэр бүхий 5 Гишүүн үнэт цаасны компанид 2017 оны гишүүнчлэлийн жилийн хөлсөөс тус бүр 10 хувийн хөнгөлөлт эдлүүлсүгэй.
2. Гишүүнчлэлийн жилийн хөлсийг хөнгөлсөн дүнгээр тооцон авах, нэгдүгээр улиралд гишүүнчлэлийн хөлс төлсөн компаниудын хөнгөлөлтийг хоёрдугаар улирлын хөлсөөс хассан дүнгээр тооцон нэхэмжлэхийг Захиргаа, санхүүгийн газрын Санхүүгийн алба /Н.Уянга/-нд даалгасугай.
3. Тушаалын биелэлтэд хяналт тавих, гишүүн компаниудад мэдэгдэх ажлыг Хяналт, зохицуулалтын газрын Хяналт, шинжилгээний алба /Д.Баттулга/-нд даалгасугай.

ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ



Х.АЛТАЙ

“МХБ” ТӨХК-ийн Гүйцэтгэх захирлын
2017 оны 02 дугаар сарын 03-ны өдрийн
А.10 дугаар тушаалын хавсралт



Д/Д	БДК-ийн нэр	Нийт үнийн дүн	Эзлэх хувь
1	“БиДиСек ҮЦК” ХК	136,222,532,165	32.67%
2	“Новел инвестмент ҮЦК” ХХК	66,866,112,221	16.04%
3	“Ти Ди Би Капитал ҮЦК” ХХК	63,034,099,504	15.12%
4	“Тэнгэр капитал ҮЦК” ХХК	46,254,974,152	11.09%
5	“Ард секюритиз ҮЦК” ХХК	21,149,161,258	5.07%